



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Сонгуулийн хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.3, 13.4, 13.6 дахь хэсгийг тус тус үндэслэн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус XXVI хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулах хүрээнд нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа, хаягийн бүртгэлтэй сонгогчийн тоог үндэслэн Багахангай дүүргийн сонгуулийн 1 дүгээр хэсгийг нэгдүгээр хорооны нутаг дэвсгэрээр тогтоож, хэсгийн төвийг Биеийн тамир, спортын хорооны байранд, 2 дугаар хэсгийг хоёрдугаар хорооны нутаг дэвсгэрээр тогтоож, хэсгийн төвийг "Хангай" цогцолбор сургуулийн хичээлийн хоёрдугаар байранд байхаар тус тус тогтоосугай.

2. Тогтоолыг хуулийн хугацаанд Сонгуулийн Ерөнхий хороо, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дүүргийн Улсын Бүртгэлийн хэлтэст тус тус хүргүүлж, нутаг дэвсгэр, хэсгийн төвийг зарлан иргэдэд мэдээлэл хүргэж ажиллахыг Хурлын Ажлын алба (М.Давааням)-нд даалгасугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ